

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ТҮҮНТЭЙ ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Сүүлийн хориод жилд Монгол Улсын эрх зүйн салбарт олон тооны хууль тогтоомж батлагдан гарч, мөрдөгдөж ирсэн. Ялангуяа шүүхийн зохион байгуулалт, материаллаг бааз бэхжихийн хэрээр түүний үйл ажиллагаанд ахиц дэвшил гарч, улс орны хөгжилд чухал хувь нэмэр оруулж байна.

Тухайлбал, өнгөрсөн хугацаанд шүүх эрх мэдлийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр дараах бодлогын баримт бичгүүд батлагдан хэрэгжиж ирсэн.

Улсын Их Хурлаас 1998 онд баталсан "Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр"-ийн хүрээнд Шүүхийн тухай хуулийг 2002 онд шинэчлэн баталж өнөөгийн шүүхийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлжээ. Шүүхийн шинэчлэлийн бодлогын анхны баримт бичиг болох "Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө" -г Улсын Их Хурлын 2000 оны 39 дүгээр тогтоолоор баталсан нь эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ялангуяа шүүх эрх мэдлийн байгууллагуудыг бэхжүүлэхэд ач холбогдолтой болсон.

Гэвч энэ салбарт шийдвэрлэх ёстой, тулгамдсан олон асуудал шийдлээ хүлээсээр байна. Улс үндэстэн хурдацтай хөгжиж, эдийн засгийн үр өгөөжөө нэмэгдүүлж чадах эсэхийг тодорхойлогч нэг хүчин зүйл нь шударга, бие даасан, чадварлаг шүүх гэдгийг олон улсын судалгаа харуулж байна. Тухайлбал, шүүхийн тогтолцоо сул, үйл ажиллагаа нь чанаргүй бол нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ болон хөрөнгө оруулалтыг 10 хүртэл хувиар бууруулдаг байна. Ийм учраас хүний эрх, эрх чөлөө, ардчилал, хөрөнгө оруулалт, нийгэм, эдийн засгийн хөгжлийн чухал баталгаа болсон шүүхийн үйл ажиллагааг цаашид улам бүр боловсронгуй болгох, институтын хувьд чадавхийг нь бэхжүүлэх, хариуцлагатай, ил тод байдлыг нэмэгдүүлэх нь дан ганц шүүх, хуулийн салбарынхны төдийгүй олон нийтийн хүсэн хүлээж буй нийгмийн захиалга болж байна. Иймд шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгож, бие даасан, хараат бус байдлыг нь хангах замаар хэрэг, маргааныг хүндрэл чирэгдэлгүй, шударгаар шийдвэрлэхэд чиглэсэн өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжид оруулах, шүүхийн үйл ажиллагааг шинэ түвшинд гаргах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Шүүх эрх мэдэлтэй холбоотойгоор тусгайлан хуулиар зохицуулахаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан нийгмийн харилцааг журамлаж, шүүхийн эрх зүйг бүрэн утгаар нь бий болгоход чиглэсэн хуулийн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна. Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа Шүүхийн тухай хууль нь нийгмийн хөгжил, салбарын эрэлт хэрэгцээг бүрэн дүүрэн хангаж чадахгүй байна. Нийгэм дэх шүүхийн гүйцэтгэх үүрэг, оролцоо их болсон өнөө үед шүүхийн институтыг бэхжүүлэх, шүүгчийн хараат бус байдлыг хангах, ур чадвар, ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх, шүүхийн үйлчилгээг чанартай, хүндрэл чирэгдэлгүй хүргэх зэрэг олон чухал зорилтыг ганц хуулийн зохицуулалтаар бус, тус тусын нарийвчилсан хуулиар зохицуулах замаар аль болох иж бүрнээр шийдвэрлэх шаардлагатай юм.

Нийгмийн энэхүү захиалга, шаардлагыг харгалзан үзэж Монгол Улсын Ерөнхийлөгчөөс боловсруулсан “Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх” хөтөлбөрийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл 2010 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хурлаараа хэлэлцэн дэмжсэн.

Түүнчлэн, Ерөнхийлөгчийн санаачилгаар 2011 оны 4 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Шүүх эрх мэдлийн шинэчлэл ба шударга ёс” үндэсний чуулганд шүүх, хууль сахиулах байгууллагын төлөөлөл болон иргэд шүүх эрх мэдлийн салбарт хийвэл зохих шаардлагатай өөрчлөлт, шинэчлэл, эрх зүйн орчин, зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар үнэтэй санал, зөвлөмж гаргасан.

Энэ бүхний дүнд шүүхийн тогтолцоог шинэчлэх, бие даасан, хараат бус байдлыг хангах, шударгаар хэрэг, маргааныг шийдвэрлэх тогтолцоог бий болгох, шүүхийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх зорилгоор Шүүхийн тухай /Шинэчилсэн найруулга/, Шүүхийн захиргааны тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн төслүүдийг боловсрууллаа.

Үүнээс гадна хуульчийн эрх зүйн байдал, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, түүний хууль зүйн үр дагаварыг тодорхойлох, хуульчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагын тогтолцоо, мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тогтоож, хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг бүрдүүлсэн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулж байна.

Эдгээр хуулийн төсөл нь тус улсын шүүхийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх амин чухал асуудлууд болсон шүүхийн бие даасан, нээлттэй, ил тод байдлыг хангах, шүүхийн ажлын ачааллыг зохистой болгох, шүүгч хэрэг, маргааны төрлөөр мэргэших, шүүхийн төсөв, захиргааг бие даалгах замаар хэрэг, маргааныг шударга шүүхээр шийдвэрлүүлэх Үндсэн хуулийн зарчмыг бодитойгоор хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх юм.

Хуулийн төслүүдийг тус бүрээр нь танилцуулбал:

1. Шүүхийн тухай хуулийн төсөл

Шүүхийн ажлын ачаалал хот суурин газар, хөдөө орон нутагт харилцан адилгүй байдгаас эдийн засгийн үр ашгийн хувьд учир дутагдалтай байна. Түүнчлэн, шүүхийн тогтолцоо нь орон нутгийн засаг захиргаанд тулгуурласанаар тухайн засаг захиргааны хөндлөнгийн нөлөөлөл бий болгож байна. Энэхүү асуудлыг шийдвэрлэх үүднээс шүүхийн тогтолцоог нутаг дэвсгэрийн байршил, хүн амын нягтаршил, хэрэг, маргааны шийдвэрлэлтийн тоо зэргийг харгалзан тойргийн зарчмаар байгуулах нь зүйтэй гэж үзлээ.

Аливаа иргэн, эрүү, захиргааны маргааныг шийдвэрлэхэд шүүгчийн тухайн салбарын нарийн мэдлэг, мэргэшсэн байдал нь нэн чухал байдаг ба энэ нь иргэний шударга шүүхээр шийдүүлэх эрхийн нэг үндэс болдог тул анхан болон давж заалдах шатны шүүхийг эрүү, иргэн, захиргаа зэрэг хэрэг, маргааны төрлөөр дагнан байгуулахаар хуулийн төсөлд тусгав.

Энэхүү хуулийн төсөл нь:

- Нийтлэг үндэслэл;
- Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх зарчим;
- Монгол Улсын шүүх;
- Монгол Улсын дээд шүүх;
- Давж заалдах шатны шүүх;
- Анхан шатны шүүх;
- Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх батагаа;
- Бусад зүйл гэсэн нийт 8 бүлэг, 33 зүйлтэй байх бөгөөд шүүхийн зохион байгуулалт, тогтолцоо, бүрэн эрх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх баталгаа болон үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулна.

2.Шүүхийн захиргааны тухай хуулийн төсөл

Шүүхийн шүүн таслах үйл ажиллагааны тасралтгүй байдал, өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, улмаар шүүхийн бие даасан байдлыг хангах чиг үүрэгтэй шүүхийн захиргааны тухай ойлголт, түүний чиг үүрэг, эрх хэмжээний асуудал өнөөг хүртэл тодорхойгүй явж ирсэн. Ялангуяа, шүүхийн захиргааны үндсэн байгууллага болох Шүүхийн ерөнхий зөвлөл болон шүүхийн тамгын газрын захиргааны болон бусад чиг үүрэг бүрхэг, түүнчлэн шүүхийн захиргаанд ач холбогдол өгдөггүйгээс шүүхийн шүүн таслах ажиллагааг хэвийн, үр дүнтэй явуулахад хүндрэл бэрхшээл тулгардаг.

Энэхүү хуулийн төсөл нь:

- Нийтлэг үндэслэл;
- Ерөнхий зөвлөлийн бүрэн эрх, чиг үүрэг;
- Ерөнхий зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн;
- Шүүхийн захиргааны байгууллага;
- Шүүхийн ажилтны эрх зүйн байдал;
- Бусад зүйл гэсэн нийт 6 бүлэг, 32 зүйлтэй болно.

Энэхүү хуулийн төслийн зорилт нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, шүүхийн өдөр тутмын тасралтгүй үйл ажиллагааг зохион байгуулах үндсэн чиг үүрэг бүхий Шүүхийн ерөнхий зөвлөл болон шүүхийн захиргааны чиг үүрэг, зохион байгуулалт, үйл ажиллагааны

зарчим, шүүхийн ажилтны эрх зүйн байдлыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Шүүхийн ерөнхий зөвлөл болон шүүхийн тамгын газар нь шүүх, шүүгчийн үйл ажиллагаанд оролцохгүйгээр тэдгээрт хараат бус, бие даасан байдлыг зохион байгуулалт, санхүү, эдийн засгийн болон хэвийн ажиллагааны бусад нөхцөлөөр хангаснаар шүүх эрх мэдлийн байгууллагын үндсэн үйл ажиллагааг аливаа нөлөөнөөс хамгаалах механизм бүрдэнэ.

3. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл

Шүүгчийн шалгуур, ёс зүй, хариуцлага болон шүүгчийн сонгон шалгаруулалтын журам тодорхойгүйгээс шүүгчийн ур чадвар, шударга байдал олон нийт эргэлзэх, авлигад сэрдэх явдал гарч байна. Нөгөө талаас, шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах, хөндлөнгийн нөлөөнөөс урьдчилан сэргийлэх механизм байхгүйгээс нөлөөлөх оролдлого, үйлдэл гаргаад байгааг олон удаагийн судалгаа харуулсан. Иймээс шүүхийн шинэчлэлийн нэг чухал хэсэг болох шүүгчийн шалгуурыг тодорхой болгох, босгыг өндөрсгөх, сонгон шалгаруулах журмыг нарийвчлан зохицуулах, шүүгчийн хараат бус байдлыг хангах баталгааг бий болгож, улмаар шүүгчдийн мэргэшлээрээ дагнасан, чанартай үйлчилгээг үзүүлэх нөхцөл бүрдүүлэх нь чухал юм.

Энэхүү хуулийн төсөл нь:

- Нийтлэг үндэслэл;
- Шүүгчийн эрх зүйн байдлын нийтлэг үндэслэл;
- Шүүгчийн бүрэн эрх үүсэх, дуусгавар болох;
- Шүүгчийн хараат бус байдал, түүнийг хангах баталгаа;
- Шүүгчийн хариуцлага;
- Хүлээлгэх хариуцлага;
- Бусад гэсэн нийт 7 бүлэг, 40 зүйлтэй.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх онцгой чиг үүрэг бүхий шүүгчид тавих шаардлага, шүүгчийн бүрэн эрх үүсэх ба дуусгавар болох үндэслэл, журам зэрэг шүүгчийн эрх зүйн байдалтай холбогдсон харилцааг зохицуулахад хуулийн зорилго оршино.

Монгол Улсын бүх шатны шүүхийн шүүгчийн хараат бус, халдашгүй, эрх мэдэл бүхий, шударга, хариуцлагатай байдлыг хангах, үйл ажиллагаандаа хууль дээдлэх ёс, шүүхийн ёс зүйг нарийн чанд сахин биелүүлэх эрх зүйн үндсийг тогтоон зохицуулна.

4. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл

Монгол Улсын Үндсэн Хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 2-т анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна гэж заасан. Энэ нь иргэдийн төлөөлөгчийг шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх процессийн чухал бүрэлдхүүн хэсэг болгон баталгаажуулсан явдал юм.

Иргэдийн төлөөлөгчийн эрх хэмжээ болон холбогдох харилцааг Шүүхийн тухай болон Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх зэрэг хуулиар зохицуулсан байдаг.

Иргэдийн төлөөлөгч нь нотлох баримтыг үнэлэх, шүүгдэгч, гэрч, хохирогчоос асуулт асуух, шүүмжлэлийн үед үг хэлэх зэрэг шүүх хуралдаанд оролцох боломжоор хангагдсан хэдий ч иргэдийн төлөөлөгчийг сонгох, шүүх хуралдаанд оролцуулах, цалин хөлс олгох болон бусад харилцаа нь нарийн зохицуулагдаагүйгээс хэлбэрийн төдий хэрэгждэг, иргэдийн төлөөлөгчид нь ч идэвхгүй байр суурьтай байдгаас болж Үндсэн хуульд заасан энэхүү чухал механизм төдийлөн ач холбогдолгүй болсон байна.

Иргэдийн төлөөлөгчийн эрх хэмжээ, оролцох механизм болон зохион байгуулалтыг хуулиар нарийн зохицуулах нь иргэдийн төлөөлөгчийн оролцоог баталгаажуулж, улмаар Үндсэн хуулийн үзэл санааг бодит утгаар хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой болно.

Олон улсын практикт шүүх ажиллагаан дахь иргэдийн оролцооны “jury” буюу тангарагтны шүүгчид, “lay judge” буюу мэргэжлийн бус шүүгч гэсэн хоёр загвар байдаг. Тангарагтны шүүхийн хувьд тодорхой тооны иргэд шүүгчийн оролцоогүйгээр хэргийг факт буюу гэм буруугийн хувьд шийдвэрлэдэг бол мэргэжлийн бус шүүгч нь мэргэжлийн шүүгчидтэй хамтран гэм буруугийн болон бусад асуудлаар шийдвэр гаргахад оролцдог ороо ялгаатай.

Тангарагтны шүүхийн хувьд Хойд Америк, Их Британи түүний колони байсан орнуудад түгээмэл бол мэргэжлийн бус шүүгчийн оролцооны загвар нь эх газрын эрх зүйн тогтолцоотой Герман, Финланд, Швед, Польш зэрэг Европын улс орнуудад байдаг. Мөн Украин, Гүрж, Азербайжан, Казахстан, Узбекистан, Тажикстан, ОХУ зэрэг шилжилт хийсэн улсууд шүүхийн тогтолцоондоо иргэдийн оролцооны механизмыг оруулсан байна.

БНСУ, Япон зэрэг улсууд саяхнаас иргэдийн оролцоотой шүүхийн тогтолцоонд шилжсэн ба БНХАУ-ын хувьд иргэдийн оролцоотой тогтолцоогоо улам сайжруулж байна.

Хүний үндсэн эрхийн нэг нь хууль ёсны дагуу байгуулагдсан, бие даасан, хараат бус шүүхээр хэрэг, маргаанаа шударгаар шүүлгэх эрх билээ. Шударга шүүхийн нэг гол зарчим нь шүүхийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх явдал юм. Шүүхийн нээлттэй, ил тод байдлыг хангах нэг гол нөхцөл нь иргэдийн шүүх үйл ажиллагаанд оролцох боломж бөгөөд үүнийг шүүхийн хараат бус байдлын зарчимтай уялдуулан харилцан тэнцвэрийг хадгалснаар шүүхийн үйл ажиллагааг

иргэд ажиглах, шүүхийг хариуцлагатай, нээлттэй үйл ажиллагаа явуулахад чухал ач холбогдолтой.

Ийм учраас шүүх эрх мэдлийн байгууллагад ардчилсан, нээлттэй байх зарчмыг бэхжүүлэх, шүүн таслах ажиллагаанд олон нийтийн зүгээс хяналт тавих механизм бий болгох зорилгоор шүүн таслах ажиллагаанд оролцож байгаа иргэдийн төлөөлөгчийн институтыг бэхжүүлэх нь шүүх эрх мэдлийн шинэчлэлийн нэн чухал бүрэлдэхүүн хэсэг болно.

Энэхүү хуулийн төслийг боловсруулахдаа ХБНГУ, Франц, АНУ, БНСУ зэрэг улсын холбогдох хууль тогтоомж, судалгааны материалыг судлан үзлээ.

Энэхүү хуулийн төсөл нь шүүн таслах ажиллагаанд оролцож байгаа иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах, түүний үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Энэ хуулиар иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн статус, шалгуурыг тодорхойлж, иргэдийн төлөөлөгчийг шүүх хуралдаанд бодитой, үр нөлөөтэй оролцох боломжийг бүрэн нээж, холбогдох зохицуулалтыг нарийвчлан оруулсан. Түүнчлэн иргэдийн төлөөлөгчийн оролцоог хангах талаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүргийг тодорхойллоо.

Энэхүү хуулийн төсөл нь:

- Нийтлэг үндэслэл;
- Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн бүрэн эрх, түүнд тавих шаардлага;
- Иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах;
- Иргэдийн төлөөлөгч шүүн таслах үйл ажиллагаанд оролцох;
- Иргэдийн төлөөлөгчийн ажиллах нөхцөл, хөлс;
- Хүлээлгэх хариуцлага гэсэн 7 бүлэг 23 зүйлтэй.

Иргэдийн төлөөлөгчийн эрх хэмжээг тодорхой болгосноор, шүүхийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод, шударга байх олон нийтийн үнэлэмж дээшилж нийгмийн шүүхэд итгэх итгэл, хандах хандлага сайжирна. Түүнчлэн, иргэдийн эрх зүйн ухамсар дээшлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

5.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн төсөл

Хот, суурин газрууд дахь хүн амын нягтаршил, шилжилт хөдөлгөөн ихэсч байгаа нь шүүхийн ажлын ачааллыг нэмэгдүүлж, улмаар шүүхээс иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг багасгах, чирэгдэл, цаг хугацааны болон бусад үргүй зардлыг ихэсгэж байгааг дан ганц шүүхийн орон тоо, хүний нөөцийг нэмэх замаар шийдвэрлэх нь оновчгүй тул эрх зүйн маргааныг шийдвэрлэх өртөг зардал багатай, хялбар шинэ механизмыг нэвтрүүлэн, холбогдох хууль тогтоомжид тусгах шаардлага амьдралаас урган гарч байна. Үүний шийдэл нь эвлэрүүлэн зуучлалын механизм нэвтрүүлэх явдал юм.

Аливаа маргааныг маргалдагч талуудын зөвшилцөлийг ололгүйгээр хүчээр шийдвэрлэх нь маргааныг дуусгавар болгохоос илүү түүнийг далд байдалд оруулах, эсхүл цаашид үргэлжлэхэд хүргэдэг байна. Ийм учраас оролцогч талууд маргааныг шийдвэрлэхэд өөрсдөө идэвхитэй оролцох нь илүү үр дүнтэй, чухал ач холбогдолтой байна.

Талууд маргаанаа эвлэрүүлэн зуучлуулснаар шүүхийн ачааллыг багасгаж, төрийн ачааг хөнгөвчлөх, иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, учирсан хохирлыг хялбар арга замаар барагдуулах зэрэг тал бүрийн ач холбогдолтой.

Монгол Улсын шүүн таслах ажиллагааны статистик мэдээнээс үзэхэд анхан шатны шүүхүүд нэг жилд шийдвэрлэдэг 30 гаруй мянган иргэний хэргээс 30-40 хувийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн байна. Энэ нь манай улсад эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааны эрэлт хэрэгцээ их байгааг харуулж байна.

Эвлэрүүлэн зуучлалыг нэвтрүүлэх нь шүүх эрх мэдлийн шинэчлэлийн нэн чухал хэсэг болно. Маргааныг эвийн журмаар, шүүхээс өмнө шийдвэрлэх шинэ механизмыг бий болгох нь шүүхийн ачааллыг эрс багасган шүүхийн үйл ажиллагааны чанарт ч нөлөөлнө. Эвлэрүүлэн зуучлуулах үйл ажиллагааг нэвтрүүлэхийн ач холбогдлын талаар 2011 оны 4 дүгээр сарын 14-15-нд болсон “Шүүх эрх мэдэл ба шударга ёс” үндэсний чуулганаас гарсан санал зөвлөмжид тусгагдсан билээ.

Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь дэлхийн улс орнуудын шүүхийн практикт харьцангуй шинэ боловч эрх зүйн өөр өөр тогтолцоотой орнуудын шүүхийн практикт өргөн нэвтэрч байна. Судалгаанаас үзэхэд, эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг нэвтрүүлснээр шүүхийн ачаалал 70 хүртэл хувь буурдаг болохыг Япон улсын жишээ харуулж байна. Энэхүү хуулийн төслийг боловсруулахад Япон, Австрали, ОХУ, Казахстан, Молдов зэрэг улсын хуулиудыг судалсан.

Энэхүү хуулийн төсөл нь :

- Нийтлэг үндэслэл;
- Эвлэрүүлэн зуучлуулах үйл ажиллагааны төрөл;
- Эвлэрүүлэн зуучлуулах үйл ажиллагааны оролцогч;
- Эвлэрүүлэн зуучлуулах байгууллага;
- Эвлэрүүлэн зуучлуулах үйл ажиллагааны журам;
- Зарим төрлийн маргааны талаарх эвлэрүүлэн зуучлуулах үйл ажиллагаа;
- Бусад зүйл гэсэн нийт 7 бүлэг, 32 зүйлээс бүрдэнэ.

Энэхүү хууль нь иргэний эрх зүйн харилцаанаас үүссэн, тэдгээрийн дотор аж ахуйн болон эдийн засгийн бусад үйл ажиллагаатай холбоотой маргаан, түүнчлэн хөдөлмөрийн болон гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хэрэглэх харилцааг зохицуулна.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулахдаа талууд хүсэл зоригоо харилцан зөвшилцөх, сайн дур, талуудын тэгш эрх, зуучлагчийн хараат бус, хөндлөнгийн байдал, нууцлалыг хадгалах зэрэг зарчмуудыг баримтална.

Шүүхэд тулгуурласан эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа нь шүүхийн тогтолцооны нэг бүрэлдхүүн хэсэг бөгөөд зохион байгуулалтаар хангах чиг үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөл хариуцаж, холбогдох зуучлалын үйл ажиллагааны зардлыг шүүхийн төсөвт тусгаж байх болно.

Шүүхийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх арга хэмжээний хүрээнд боловсруулсан хуулийн төслүүдийн талаар 2011 оны 02 дугаар сарын 14-ний өдөр Засгийн газраас ирүүлсэн 20 саналын 19-ийг нь хүлээн авч хуулийн төсөлд дараах байдлаар тусгав. Үүнд:

1. “Шүүх эрх мэдлийн байгууллага” гэсэн нэр томъёог хуулийн төсөлд өргөнөөр хэрэглэснийг өөрчлөн, Үндсэн хуулийн цэц, прокурорын байгууллагын чиг үүрэгтэй холбоотой заалтуудыг хассан;
2. Шүүгчийн мэргэжлийн ур чадвар, ажлын ачааллыг бууруулах нэгэн хэлбэр гэсэн байдлаар томъёолон төсөлд тусгасан “дадлагажигч шүүгчийн” талаарх зохицуулалтыг төслөөс хассан;
3. Улсын дээд шүүхийн болон шүүхийн бүрэн эрхтэй холбоотой заалтыг хүлээн авч хуулиар харъяалуулсан тодорхой хэрэг, маргааныг анхан болон давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэж байх тухай заалт, шүүхээс гэм буруутай этгээдэд “эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хэрэг үүсгэх” тухай заалтыг бүрэн хассан;
4. Эвийн шүүгчийн эрх зүйн статусыг нягтлах нь зүйтэй гэсэн саналыг судлан үзэж, Эвийн шүүгчийн тухай заалтыг хуулийн төслөөс хасч, шүүхийн бус журмаар “Эвлэрүүлэн зуучлалын тухай” хуулийн төслийг тусгайлан боловсруулсан;
5. Шүүгчийн дипломат ямба, хөрөнгө орлогын мэдүүлэг болон шүүгчийн туслах, шүүх хурлын нарийн бичгийн даргыг төрийн тусгай албан хаагчийн ангилалд хамруулахаар төсөлд тусгасныг хасах саналыг хүлээн авч, хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн зохицуулалтыг хэвээр үлдээсэн;
6. “Шүүгчдийн хамтын нийгэмлэгийн тухай” хуулийн төслийг бүхэлд нь хасав;
7. Түүнчлэн хуулийн төслийг батлан гаргахтай зэрэгцэн бий болох нийгэм, эдийн засгийн тооцоог хуулийн үзэл баримтлалд тусгалаа. /Эдийн засгийн тооцоог хавсаргав/
8. Хуулийн төслийн нэр, томъёо, найруулга, үг хэллэгтэй холбоотой саналыг хүлээн авч холбогдох өөрчлөлтийг хийв.

Хуулийн төслүүдийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимаар нийт 6 удаа хэлэлцүүлж, Засгийн газрын санал, “Шүүх эрх мэдэл ба шударга ёс” Үндэсний чуулганаас гаргасан санал, дүгнэлт, гадаад, дотоодын нэрт эрдэмтэн, судлаачдын зөвлөмж, хуулийн байгууллагуудын болон иргэний нийгмийн санал бодлыг хүлээн авч УИХ-ын гишүүдтэй ажил хэрэгч уулзалт, зөвлөлгөөн хийсэн. Мөн хуулийн төслийг цахим хуудсанд байрлуулж иргэдийн санал бодлыг авснаас гадна энэ чиглэлээр хийгдсэн судалгааны ажил, бичигдсэн

ном зохиол, бусад эх сурвалжийг судлан үзэж мөн гадаад орнуудын туршлагыг харгалзан үзлээ.

Мөн “Шүүх эрх мэдлийн шинэчлэл ба шударга ёс” үндэсний чуулганы гаргасан хийвэл зохих шаардлагатай өөрчлөлт, шинэчлэл, эрх зүйн орчин, зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар санал, зөвлөмжийг Шүүхийн тухай болон түүнтэй холбогдох бусад хуулийн төсөлд тусгасан болно.

Дээр дурдсан хуулийн төслүүдтэй холбогдуулан Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай, Прокурорын тухай, Өмгөөллийн тухай, Арбитрын тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Гэр бүлийн тухай, Олон улсын гэрээний тухай, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулсан болно.

Шүүх эрх мэдлийн эдийн засгийн баталгаа болгож Шүүхийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төсөлд шүүхийн төсвийг Шүүхийн ерөнхий зөвлөл боловсруулан Улсын Их Хуралд шууд өргөн мэдүүлэхээр тусгасан. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд зохих өөрчлөлт оруулах шаардлагатай бөгөөд Засгийн газраас өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаатай холбогдуулан эдгээр төслийг боловсруулаагүй болно. Төсвийн тухай хуулийн төсөлд шүүхийн төсвийг шүүхийн бие даасан байдлыг нь хангах үүднээс Улсын Их Хуралтай адил зарчмаар шийдвэрлэж өгөхийг хүсье.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ